

# Судалгааны Тойм

№22 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

## НОТОЛГООНЫ ӨНӨӨГИЙН ПРАКТИК, АРГА ЗҮЙ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, АНХААРАХ АСУУДАЛ

### ТОВЧ ТАЙЛБАР

“Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”<sup>1</sup>, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”<sup>2</sup> зэрэг бодлогын баримт бичгийн хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад чиглэсэн хэд хэдэн чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсний нэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ гэх)-ийг баталсан явдал юм.<sup>3</sup>

ЭХХШТХ нь өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиас хэлбэр, агуулга,

зарчмын хувьд ихээхэн ялгаатай. Тухайлбал, “байцаалт”-д тулгуурласан нотолгооноос техник хэрэгсэл, арга зүйд тулгуурласан нотолгооны процесст шилжих алхам хийгдсэн. Үүний дүнд мөрдөгч нотолгооны шинэ арга барил, техник хэрэгсэл ашиглан болж өнгөрсөн үйл явдлыг хөдөлшгүйгээр нотолж, хэргийг түргэн шуурхай илрүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд энэ нь шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх гол хүчин зүйл билээ. Уг тоймоор дээрх судалгааны гол үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох талуудад хүргэхийг зорьсон ба судалгааг бүрэн эхээр нь [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас татаж үзнэ үү.

### СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд нотлох ажиллагаатай холбоотой тоон мэдээлэл, ганцаарчилсан болон фокус-бүлгийн ярилцлагаар цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мөн шүүхийн шийдвэрүүд болон гадаад орны хууль тогтоомжийг судлах зэрэг арга зүйг ашигласан болно.

Гэмт хэргийн нотлох ажиллагааны эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийхдээ холбогдох хууль тогтоомжийг судлахын зэрэгцээ гадаад орны эрх зүйг харьцуулан судаллаа. Энэ хүрээнд

Эрүүгийн процессын загвар хууль, Англи, АНУ, БНХАУ, БНСУ, ОХУ-ын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийв. Мөн Улаанбаатар хот, Төв, Өвөрхангай, Дархан-Уул, Ховд, Өмнөговь, Хэнтий аймгуудын 73 мөрдөгч, мөрдөн байцаах болон эрүүгийн цагдаагийн тасгийн дарга нар, 10 шинжээч, 30 өмгөөлөгч, 21 прокурор, 5 шүүгчтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийлээ. Үүний зэрэгцээ Улаанбаатар хотын гурван дүүрэг, хоёр аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоол “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралт

<sup>3</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн.

2018-2020 онуудад хянан шийдвэрлэгдсэн түгээмэл үйлдэгддэг, хэргийн нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд мөрдөгч, шинжээчийн ур чадвар, хэргийн газрын үзлэг, эд мөрийн баримт шаарддаг гэсэн шинжээр сонгосон нийт 120 хэргийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийсэн болно.<sup>4</sup>

Нотлох ажиллагааны ур чадварыг хэрхэн олгож буйг үнэлэх зорилгоор МУИС-ийн Хууль зүйн

## СУДАЛГААНЫ ДҮН

ЭХХШТХ хэрэгжээд 3 жил өнгөрч байхад мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нар ЭХХШТХ-ийн үзэл баримтлал, шинэ төрлийн нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх аргуудын талаар нэгдсэн ойлголт байхгүй, шинэлэг зохицуулалтуудыг ашиглахын оронд уламжлалт хуучин арга, тактикаар нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх нь давамгайл байна. Мөрдөгч, шүүгч нарын хувьд хуулийг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээлээ хуульд нялзаах хандлага давамгайлжээ. Ийм нөхцөлд судалгаанд үндэслэхгүйгээр Эрүүгийн болон Эрүүгийн процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь нь хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдалд хохирол учруулах эрсдэлтэй.

Нөгөө талаас, эрүүгийн процессын хууль байнга шинэчлэгдэж байхыг шаарддаг. Учир нь, гэмт этгээдүүд үйлдлийн аргаа улам боловсронгуй болгож, илрүүлэхэд төвөгтэй болгосоор байна. Тэдэнд хуулийн хариуцлагыг зайлшгүй хүлээлгэх үүднээс өөрчлөгдөн буй нөхцөл байдалд тохирсон холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хуульд тухай бүрд оруулах нь гарцаагүй нөхцөл юм. Тиймээс хуульд ойр ойрхон өөрчлөлт оруулах зохимжгүй гэсэн хандлагаа өөрчлөх нь зүйтэй. Эрх зүйн орчныг сайжруулж байгаа орны туршлагаас харахад процессын хуульд ойр ойрхон өөрчлөлт оруулах замаар алгуур шилжилт хийх хандлага байна.

Нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлэхэд техник хэрэгслийн ололт, дэвшлийг ашиглах эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрджээ. 2016 оноос хойш нийгмийн аливаа харилцааг дүрэм, журмаас илүүтэйгээр хуулийн хүрээнд зохицуулах болсон нь том дэвшил юм. Гэвч мөрдөгч нар нотлох

сургууль, Дотоод хэргийн Их сургууль, Их Засаг Олон Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Билэг дээд сургуулийн сонсогч, оюутнуудад зааж буй сургалтын хөтөлбөр, гарын авлага, сурах бичигт мөн дүн шинжилгээ хийв. Тэрчлэн шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн болон шинжилгээ, туршилт хийж гүйцэтгэдэг бусад байгууллагын үйл ажиллагааг харьцуулан судаллаа.

ажиллагаандаа шинэ төрлийн нотолгооны арга, техник хэрэгслийг төдийлөн ашиглахгүй байна. Иймд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх болон тэдгээртэй уялдан бий болдог зохицуулалтыг нарийвчлан хуульчлах шаардлага тулгарч байна. Уг хуулиар нотлох баримттай ажиллах наад захын жишгийг тогтоож өгснөөр мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нар нэгдсэн ойлголттой болох боломжтой. Өмгөөлөгч нарын хувьд өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан техник хэрэгсэл ашиглах сонирхол өндөр байгаа ч нарийвчилсан зохицуулалт байхгүйн улмаас мөрдөгч, прокурор, шүүгчийн үзэмжээс хамаарч асуудал нь шийдэгдэж байна.

Шинэ хуулийн орчинд хэрэг хянан шийдвэрлэх удирдлага зохион байгуулалт дутмаг, хэдийгээр шинэ төрлийн болон зохион байгуулалттай гэмт хэргийг нотлох ажиллагаанд дэвшил гарч байгаа ч орон нутагт энэ чадавх сул байна. Харин нийтлэг үйлдэгддэг гэмт хэргийг нотлох ажиллагаа нь уламжлалт арга барилаар явагдсаар байна. Нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэж болохоор заасан ч мөрдөгч нар дуу-дүрсний бичлэг, гэрэл зургийн аппарат зэргээс өөр техник хэрэгслийг түгээмэл ашиглахгүй байна.

Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх, шалгах, үнэлэх арга зүйг сайжруулах чиглэлийн дорвитой ажил сүүлийн жилүүдэд хийгдээгүйгээс мөрдөгч

<sup>4</sup> Цахим эх сурвалж: shuukh.mn сайт

нарын арга барил цаг үеийн шаардлагыг хангахгүй байна. Мөн анхан шатны нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлж хэргийн газарт ашиглаж байгаа жижүүрийн шинжээч, мөрдөгч нарын ул мөр, илрүүлэх бэхжүүлэх техник хэрэгсэл ердийн зориулалттайгаас гадна хуучирсан, хэрэг илрүүлэх үүргийг шинжээч хүлээдэггүй зэрэг нь хэргийн газраас нотлох баримтыг бүрэн дүүрэн цуглуулж, бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна гэж үзлээ. Мөн шүүхийн шинжилгээний байгууллагын орон нутаг дахь нэгжүүд нь нарийн шинжилгээ хийдэггүйгээс төв рүү зөөвөрлөхдөө шаардлага хангахгүй битүүмжилж ирүүлснээс зарим шинжилгээний зүйлийн чанар алдагдаж, шинжилгээ хийх боломжгүй болдог ажээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь дангаараа бүх төрлийн шинжилгээ хийх боломжгүй бөгөөд ЭХХШТХ-ийн 27.4 дүгээр зүйлд заасны дагуу нэр бүхий 11 төрийн байгууллага зарим шинжилгээг хийдэг. Гэсэн хэдий ч нэгдсэн удирдлага зохион байгуулалт, уялдаа байхгүй, дээрх байгууллагуудын мэргэжилтнүүд шинжээчийн эрх, үүргийг бүрэн ухамсарладаггүй, шинжээчийн дүгнэлтүүд хэлбэр, загварын хувьд хоорондоо эрс ялгаатай, шинжилгээний зардлыг хэрхэн тооцож олгох зэрэг асуудлыг нэг мөр шийдээгүй, үндсэн ажил нь биш тул ажил хэрэгч биш ханддаг зэргээс үүдэж гаргасан дүгнэлтийг нотлох баримтаар үнэлэхэд эргэлзээ үүсэх зэрэг хүндрэл учирдаг байна.

ЭХХШТХ-ийн талаар мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шүүгч нар харилцан адилгүй ойлголттой. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх болон тээвэрлэх, хадгалах, хамгаалах, нотлох баримтыг шинжлэн судлах, хүчингүйд тооцох

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

- ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа тодорхой байгууллагын үйл ажиллагаанд учирдаг хүндрэл бэрхшээлд тулгуурлах бус хөндлөнгийн хараат бус судалгаанд тулгуурлан байнга шинэчилж байх.
- Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах, тодорхой төрлийн гэмт хэргийг нотлох

талаар ойлголт сул байна. ЭХХШТХ-д нотлох баримтын ойлголт, нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэхэд техник хэрэгсэл ашиглах эрх зүйн орчин бүрдсэн ч шинэ хуулиар бичсэн ном, сурах бичиг ховор, судалгааны ажил цөөн байгаа нь сургалт болон практик хэрэглээнд хүндрэл учруулж байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хууль зүйн их, дээд сургуулиудад заагдаж байгаа нотлох баримт, нотлох ажиллагаатай холбоотой хичээлийг судалж үзэхэд Дотоод хэргийн их сургуульд “Гэмт хэргийн нотолгооны онол” нэртэйгээр 2 багц цагийн багтаамжтайгаар семинар, дасгал түлхүү заагддаг бол бусад их, дээд сургуульд “Нотолгооны онол” нэртэйгээр агуулгын хувьд эрүү, иргэн, захиргаа, арбитрын болон бусад хэрэг маргааны нотлох ажиллагаатай холбоотой хичээлийг лекц голчилсон онолын мэдлэгээр түлхүү оруулж байна. Үүний улмаас төгсөгчид эрүүгийн хэргийн нотлох ажиллагааны талаарх мэдлэгийг харилцан адилгүй эзэмшдэг ажээ. Мөн тухайн хичээлүүдэд орос хэл дээрх ном, сурах бичгийг түлхүү эх сурвалж болгон ашиглахын зэрэгцээ ашиглаж байгаа ном, сурах бичиг нь агуулгын хувьд нилээд хуучирсан байгааг анхаарах шаардлагатай.

Эрх зүйч мэргэжлээр төгсөж байгаа хүмүүст нотолгооны онол, нотлох баримтыг шинжлэн судлах асуудлыг шүүхийн практик, хуулийн хэрэглээ талаас, харин хууль сахиулагчаар төгсөж байгаа хүмүүст нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх, түүнийг тээвэрлэх, хадгалах, тодорхой төрлийн гэмт хэргийг шууд ба шууд бус нотлох баримтаар хэрхэн нотлох мэдлэг ур чадварыг нарийвчлан заах шаардлагатай.

онцлогийг хуульчилсан “Нотлох баримтын тухай” хуулийн төсөл боловсруулах.

- Эрүүгийн болон ЭХХШТХ-ийн хэрэгжилтийг тогтмол үнэлж, судалгаа шинжилгээ хийн, хүний эрхийг дээдэлсэн, шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглах боломжийг бүрдүүлсэн, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын стандартад нийцсэн хуулийн санал

- боловсруулдаг, сургалт, зохион байгуулалтын оновчтой арга замыг боловсруулан тогтмол үйл ажиллагаатай байх судалгааны нэгжийг ХЗДХЯ-ны дэргэд байгуулах.
- Цахим нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.
  - Эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгийг нотлох баримт болгохгүй байх заалт хуульчлагдсан. Хэдий тийм ч мэдүүлэг авахаас өөр бусад аргаар нотлох баримт цуглуулж, бэхжүүлсэн бол нотлох баримтаар тооцохгүй байх зохицуулалтыг орхигдуулжээ. Иймд ЭХХШТХ-ийн 16.12 дугаар зүйлийн 1-ийг “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандаж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь тогтоогдвол уг нотлох баримтыг энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах.
  - Өмгөөлөгч өмгөөлөх үйл ажиллагаанд техник, хэрэгсэл ашиглах боломжийг ЭХХШТХ-д нарийвчлан тусгах.
  - Төрийн болон мэргэжлийн байгууллагын хяналт шалгалт явуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй биш, цугларсан баримт мэдээлэл нь нотлох баримтын шаардлагыг хангахгүй тул шууд нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжгүй. Иймд хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож нотлох баримт, нотлох ажиллагааны нэг стандарт бий болгох.
  - Мөрдөгч нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх хуульчилсан тодорхой ажиллагаа бүрд ашиглагдах техник хэрэгслийн судалгааг “гадаад, дотоодын ололт ашиглан” хийх.
  - Мөрдөгч нарын үйл ажиллагааг хүнээс хамаарсан бус техник хэрэгсэл ашиглан явуулах боломжоор бүрэн бүрдүүлэх, урсгал зардлыг сайтар тооцох.
  - Мөрдөгч, шинжээч нарыг техник хэрэгслээр хангахдаа ашиглах зааврыг дэлгэрэнгүй хавсаргах.
  - Мөрдөгч нарын үйл ажиллагааг хүнээс хамаарсан бус техник хэрэгсэл ашиглан явуулах боломжоор хангаж ажиллах, урсгал зардлыг сайтар тооцох.
  - Шүүх шинжилгээний болон төрийн хяналт шалгалтын байгууллага, төрийн байгууллагын дэргэдэх туршилт, шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудтай техник хэрэгсэл ашиглах, шинжилгээ, судалгаа, туршилт хийх чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар эрүүгийн хэргийн нотолгоог шинэ шатанд гаргах.
  - Шинжээч мэргэжилтнүүдийн судалгаа, бүртгэлтийг Шүүхийн шинжилгээний төв байгууллагад бий болгох замаар мөрдөгчдийг мэдээллээр хангах, мэргэжилтэн, шинжээч нарыг сургах.
  - Хууль сахиулагч, хуульчид нэгдсэн мэдээлэл, сургалтын гарын авлага, ном бүтээл байршуулдаг, туршлагаа солилцдог сувгуудыг өргөтгөх.
  - Эрх зүйч, мөрдөгчөөр суралцагчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг ялгамжтай тогтоон, сургагч багшийг бэлтгэн, сурах бичиг гарын авлагыг шинэ хуульд нийцүүлэн боловсруулах.
  - Өмгөөлөгч нарт техник технологи ашиглах, нотлох баримтаар тооцох, шинжлэн судлах арга замыг олгосон сургалт, мэдээлэл өгөх ажлыг эрчимжүүлэх.

#### СУДАЛГААНЫ БАГИЙН АХЛАГЧ:

Хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор Б.Батзориг

#### СУДЛААЧИД:

ДХИС-ын ЦС-ын ахлах багш, хууль зүйн магистр Б.Эрдэнэбат, Өмгөөлөгч, хууль зүйн магистр Ц.Шийтэрчүлүүн

#### ЗӨВЛӨХ:

ШШҮХ-ийн ахлах шинжээч, цагдаагийн хошууч Г.Ганхүлэг

#### СУДАЛГААНЫ ТОЙМ БОЛОВСРУУЛСАН:

Хууль зүйн магистр Б.Эрдэнэбат

#### САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:

Б.ХИШИГСАЙХАН, ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: (976) 76113207

<http://www.forum.mn>  
<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>  
[http://www.instagram.com/open\\_society\\_forum](http://www.instagram.com/open_society_forum)